



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 1/95

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 зүйл, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Архивийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн бүртгэл болон статистикийн мэдээ, тайланг хүлээн авах програм хангамжийн үйл ажиллагааг зохицуулах журмыг нэгдүгээр, цахим програмд бүртгэгдэх статистикийн мэдээ, тайлангийн бүрдлийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтэс /М.Мөнхдэлгэр/-т, Статистик, мэдээллийн хэлтэс /Н.Долгормаа/-т, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга /Л.Зэндмаа/-д даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 06 сарын 26 – ны өдрийн
1/94 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН БҮРТГЭЛ БОЛОН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ, ТАЙЛАНГ ХҮЛЭЭН АВАХ ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Нийслэлийн Эрүүл мэндийн газраас төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад олгож буй тусгай зөвшөөрлийн бүртгэл болон түүнтэй холбоотой бусад үйл ажиллагааг автоматжуулах, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын сар, улирал, жилийн мэдээ тайланг онлайн аар хүлээн авах, тайлан мэдээ өгөлтөнд хяналт тавихад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмаар нийслэлийн Эрүүл мэндийн газраас тусгай зөвшөөрөл эзэмшиж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын бүртгэл болон статистикийн мэдээ, тайланг цахим програм хангамжаар хүлээн авах, нэгтгэх, дүгнэх, нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохицуулна.

1.3 Тусгай зөвшөөрлийн бүртгэл, онлайн тайлан мэдээний програм хангамжийг “**Ubhealth**” гэж цаашид нэрлэнэ.

1.4.“**Ubhealth**” програм хангамжийн бүртгэл, тайлан нь дараах хууль, журам, стандартад нийцсэн байна. Үүнд:

- Тусгай зөвшөөрлийн бүртгэлийн модуль нь ЭМС-ийн 2018 оны А/64 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу програмчлагдан хийгдсэн байна.
- Статистикийн тайлан, мэдээний модуль нь ЭМС-ийн 2013 оны 450 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу програмчлагдсан байна.

1.5. “**Ubhealth**” програмын хэрэглэгчид:

- НЭМГ-ийн Тусгай зөвшөөрлийн алба,
- НЭМГ-ийн Статистик мэдээллийн хэлтэс,
- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага.

1.6. Дээрх талууд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. “Ubhealth” програм хангамжын бүтэц, үйл ажиллагаа

2.1. “Ubhealth” програм хангамж нь төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн бүртгэл, сар, улирал, жилийн статистик мэдээ, тайланг хүлээн авах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, нэгдсэн сан үүсгэх зориулалт бүхий вэб суурьтай онлайн програм хангамж байна.

2.2. “Ubhealth” програм хангамжийн бүтэц

“Ubhealth” програм хангамж нь

- Тусгай зөвшөөрлийн бүртгэл
- Статистик тайлан мэдээ гэсэн үндсэн 2 модультай байна.

2.3. “Ubhealth” програм хангамжид www.tailan.ubhealth.mn хаягаар хандаж нэвтрэх эрхээр нэвтэрнэ.

2.4. ЭТХ-ийн Тусгай зөвшөөрлийн алба нь эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох нийслэлийн Засаг даргын захирамж гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор тухайн тусгай зөвшөөрлийн мэдээллийг “Ubhealth” програмын тусгай зөвшөөрлийн модульд бүртгэнэ.

2.5 Статистикийн тайлан, мэдээний модуль нь:

- Сарын мэдээ,
- Улирлын мэдээ,
- Жилийн эцсийн тайлан, мэдээ гэсэн бүтэцтэй байна.

2.6. Статистикийн мэдээлэл оруулах хугацаа:

- Сарын мэдээг сар бүрийн 28-наас дараа сарын 02-ны 14 цагаас өмнө,
- Улирлын мэдээг улирал бүрийн дараа сарын 15-ны дотор,
- Жилийн эцсийн тайланг тухайн оны 12 дугаар сарын 25-наас дараа оны 01 дүгээр сарын 05-ны хооронд

2.7 Журмын 2.6-д заасан хугацаанаас хойш програмын мэдээ хүлээн авах үйл ажиллагаа дуусч, мэдээлэл оруулах функц хаагдана.

Гурав: Тусгай зөвшөөрлийн бүртгэл болон статистикийн мэдээ, тайланг солилцох үйл ажиллагаа

3.1. Тусгай зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нь статистик мэдээ, мэдээллийг илгээхдээ Нийслэлийн Эрүүл мэндийн газрын “Ubhealth” програм хангамжийг ашиглана.

3.2 Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь НЭМГ-аас тусгай зөвшөөрөл авснаар “Ubhealth” програм хангамжийг ашиглах эрх үүснэ.

3.3. НЭМГ-ын Статистик, мэдээллийн хэлтэс нь Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ, тайлан гаргах, мэдээлэх журамд заасан урсгалын дагуу ХХЭМБ-аас тайлан мэдээг хүлээн авч, нэгтгэн, холбогдох тушаал, журмын дагуу заасан хугацааг баримтлан мэдээллийг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.

3.4. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь өөрийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээлэл болон оруулсан статистик мэдээ мэдээллийг харах боломжоор хангагдсан байна.

Дөрөв: Талуудын эрх, үүрэг

4.1 НЭМГ-ын Тусгай зөвшөөрлийн алба нь:

4.1.1. Тусгай зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг Нийслэлийн Засаг даргын захирамж гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн модульд бүртгэнэ.

4.1.2. Тусгай зөвшөөрлийн модульд дараах мэдээллийг оруулна. Үүнд:

- Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн сунгалт хийх,
- Эрүүл мэндийн байгууллагын ажлын байрны шилжилт хөдөлгөөнийг тухай бүр бүртгэх, \Ажлын байрны дүгнэлт\
- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эзэмшигч, эрхлэгч \эмийн сан\ солих,
- Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны чиглэл нэмэх, хасах, өөрчлөлт оруулах,
- Аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийн эрх цуцлах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

4.1.3 Тайлан, мэдээг хугацаандаа ирүүлээгүй байгууллагыг төлөвлөгөөт хяналт, үнэлгээ хийх байгууллагын жагсаалтанд оруулна.

4.2. НЭМГ-ын Статистик, мэдээллийн хэлтэс нь:

4.2.1. Статистик мэдээ, тайлангийн модулиар батлагдсан маягтын дагуу заасан хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас тайлан мэдээг хүлээн авна.

4.2.2 Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд /клиник, ортой, сувилал, эмийн сан/ "Ubhealth" програм хангамжаар сар, улирал, жилийн эцсийн статистик тайлан мэдээг заасан хугацаанд үнэн зөв оруулсан эсэхэд хяналт тавих,

4.2.3 Статистикийн сарын мэдээг дараалан 3 болон түүнээс дээш удаа ирүүлээгүй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг нийслэлийн Эрүүл мэндийн газрын Тусгай зөвшөөрлийн албанд өгч, тухайн байгууллагын ажлын байранд хяналт, үнэлгээ хийлгэнэ,

4.2.4 Статистикийн мэдээ, тайланг авах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх үед програм хангамжтай холбоотой илэрсэн доголдлыг гүйцэтгэгч байгууллагад уламжлан засвар үйлчилгээг хийлгэх,

4.2.4."Ubhealth" програмаар хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас ирсэн тайлан мэдээг харах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх,

4.2.5 Сар, улирал, жилийн статистикийн мэдээ өгөлтийн байдалд хяналт, үнэлгээ хийж, эргэн мэдээлэл бэлтгэн байршуулах,

4.2.6. Цахим програмын "Мэдээлэл хэсэг"-т цаг үеийн болон шаардлагатай мэдээ мэдээллийг байршуулах эрхтэй байна,

4.2.7. Цахим програмын “Бүртгэлийн хэсэг”-ээс тухайн байгууллагын тусгай зөвшөөрлийн чиглэл болон холбогдох мэдээллийг харах,

4.2.8. "Ubhealth" програм хангамжийн тогтвортой үйл ажиллагааг хангах,

4.2.9. Програм хангамжийн хөгжүүлэлт шаардлагатай шинэчлэлт, өөрчлөлтийг цаг тухай бүр гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлэх, ажлын гүйцэтгэлд хяналт тавих.

4.3. Хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг

4.3.1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь “Ubhealth” програм хангамжид нэвтрэх эрхийг НЭМГ-ийн Тусгай зөвшөөрлийн албанаас авсан байна.

4.3.2. Эрх авсан өдрөөс эхлэн тухайн эрүүл мэндийн байгууллага нь энэхүү журмыг дагаж мөрдөнө.

4.3.3. Эрүүл мэндийн статистик мэдээ, тайланг Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ, тайлан гаргах, мэдээлэх журамд заасан хугацаанд “Ubhealth” програмд оруулж, илгээнэ.

Статистикийн тайлан мэдээ ирүүлэх хугацаа:

- сарын мэдээг сар бүрийн 28-наас дараа сарын 02-ны дотор,
- улирлын мэдээг 1,4,7,10 -р сарын 1-нээс 15-ны хооронд,
- жилийн эцсийн тайланг тухайн оны 12 дугаар сарын 25-наас дараа оны 1 дүгээр сарын 10-ны хооронд

4.3.4. "Ubhealth" програмд илгээж буй сар, улирал, жилийн мэдээ, тайлангийн үнэн бодит байдлыг Монгол улсын Статистикийн тухай хуулийн дагуу тухайн эрүүл мэндийн байгууллага бүрэн хариуцна.

4.3.5. "Ubhealth" програмд сар, улирал, жилийн мэдээ, тайланг илгээхээс гадна батлагдсан маягтын дагуу цахим болон цаасан хэлбэрээр өөрт хадгална.

4.3.6. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь "Ubhealth" програм хангамжид нэвтэрч тусгай зөвшөөрлийн бүртгэл болон статистик тайлан мэдээллээ харах эрхтэй байна.

4.3.7. Сар, улирал, жилийн мэдээ илгээх хугацаа дуусахаас өмнө тухайн эрүүл мэндийн байгууллага нь өөрийн илгээсэн мэдээгээ засварлах боломжтой байна.

4.3.8. "Ubhealth" програм хангамжид нэвтрэх нэр, нууц үгийн эрхийг бусдад ашиглуулах, дамжуулахыг хориглоно.

Тав: Мэдээллийн сангийн хадгалалт, ашиглалт

5.1. Тусгай зөвшөөрлийн бүртгэл болон статистик мэдээ тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу /нууцад хамаарахаас бусад мэдээллийг/ нийслэлийн Эрүүл мэндийн газрын цахим хуудсанд нээлттэй мэдээлнэ.

5.2. "Ubhealth" програм хангамж болон мэдээллийн сан нь "Үндэсний дата төв"-ийн сервэрт байрлаж ажиллана.

5.3 "Ubhealth" програм хангамжийн мэдээллийн сангийн нөөцлөлтийг НЭМГ-ын Статистик мэдээллийн хэлтэс улирал бүр хийж, хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

Зургаа: Мэдээллийн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглахад хориглох зүйл

6.1 Нийслэлийн эрүүл мэндийн газраас тусгай зөвшөөрөл эзэмшиж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын бүртгэл болон статистикийн мэдээ, тайланг "Ubhealth" програм хангамжаар хүлээн авах, нэгтгэх, дүгнэх, нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, хадгалах үйл ажиллагаанд дор дурдсан зүйлсийг хориглоно.

6.1.1. Тусгай зөвшөөрлийн мэдээлэл болон статистик мэдээ, мэдээллийг хууль бусаар ашиглах, хувийн ашиг сонирхлоор хэрэглэх, бусдад дамжуулах

6.1.2. "Ubhealth" програм хангамжийн мэдээллийн санд тусгайлан бэлтгэсэн програм болон техникийн тусламжтайгаар хууль бусаар нэвтрэх, програм хангамжийн файлыг устгах, эвдэх, ашиглах боломжгүй болгох, сүлжээг сүйтгэх

6.1.3. "Ubhealth" програм хангамжийн мэдээллийн сангийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сүлжээний найдвартай ажиллагааг алдагдуулах, эвдэх, гэмтээх

6.1.4. "Ubhealth" програм хангамжийн мэдээллийн санд хандах эрх бүхий хэрэглэгчид өөрийн нууц үгээ хамгаалах үүрэгтэй бөгөөд бусдад дамжуулах, албан ёсны давуу эрхээ хууль бус үйлдэлд болон хувийн ашиг сонирхлоор ашиглах

6.1.5. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын зөвшөөрөлгүйгээр мэдээллийн санд хандах эрх бүхий этгээд програм хангамж, мэдээллийн санг устгах, хувилж авах, тараах мөн тэдгээрийг гадны сүлжээнд холбох,

6.1.6. Нууцын зэрэглэлтэй мэдээллийг санаатайгаар болон санамсаргүйгээр хуулбарлах, ашиглах.

Долоо: Хариуцлага

7.1. Энэхүү журмыг зөрчигчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр бол бусад хууль, тогтоомж, журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Энэхүү журамтай холбоотой гомдлыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар хүлээн авч холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 06 сарын 26 – ны өдрийн
1194 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ЦАХИМ ПРОГРАМД БҮРТГЭГДЭХ СТАТИСТИКИЙН МЭДЭЭ, ТАЙЛАНГИЙН БҮРДЭЛИЙН ЖАГСААЛТ

Сарын мэдээ:

- ЭМТ 501.1–Сарын мэдээ /амбулатори, стационарын мэдээ/
- ЭМТ 501.2- Халдварт өвчний сарын мэдээ

Жилийн эцсийн тайлан:

- ЭМТ 401 - Хүний нөөцийн тайлан
- ЭМТ 402 - Хүчин чадлын тайлан
- ЭМТ 202 - Хувийн эмнэлгийн үйл ажиллагааны тайлан
- ЭМТ 203 -Сувиллын тайлан
- ЭМТ 309- Нүүр ам судлалын кабинетын тайлан
- ЭМТ 304 - Бэлгийн замын кабинетын тайлан
- ЭМТ 201.27 – Эмийн сангийн жорын тайлан